

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 01 ДҮГЭЭР САРЫН БИЕЛЭЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2026 оны 02 дугаар сарын 09

Улаанбаатар хот

Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор байгууллагын үйл ажиллагааны 01 дүгээр сарын биелэлтэд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-д заасны дагуу хяналт-шинжилгээг хийлээ.

Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын 49 арга хэмжээг төлөвлөснөөс тухайн сарын үйл ажиллагаанд 2 зорилтын 38 арга хэмжээнээс 17 арга хэмжээ буюу 34.7 хувь нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд багтсан байна.

Мөн 01 дүгээр сарын төлөвлөгөөнд Бодлогын баримт бичигт тусгагдсан нэгдүгээр зорилт “Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулах” хүрээнд Мэдээллийн технологийн хэлтсээс арга хэмжээг төлөвлөөгүй бол “Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна” буюу хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Виз, зөвшөөрлийн газар нь 2 арга хэмжээг төлөвлөхөөс 2 арга хэмжээг, Иргэний харьяаллын газар нь 5 арга хэмжээг төлөвлөхөөс 1 арга хэмжээг, Зөрчил шалган шийдвэрлэх газар нь 3 арга хэмжээ төлөвлөхөөс 2 арга хэмжээг, Зөвлөгөө, мэдээллийн хэлтэс нь төлөвлөх шаардлагатай 1 арга хэмжээг тусган хэрэгжүүлжээ. Тус зорилтод газар, нэгжүүд хамтран гүйцэтгэх шаардлагатай арга хэмжээнээс тухайн сард нэг ч арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлээгүй байна.

“Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ” буюу хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсан 30 арга хэмжээнээс тухайн сард Захиргаа, удирдлагын газар 13 арга хэмжээ төлөвлөхөөс 6 арга хэмжээг, Санхүү, хангалт, үйлчилгээний газар нь 4 арга хэмжээг төлөвлөхөөс 1 арга хэмжээг, Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс нь 3 арга хэмжээ төлөвлөхөөс нэг ч арга хэмжээг төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлээгүй, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс нь 5 арга хэмжээ төлөвлөхөөс 2 арга хэмжээг, Баян-Өлгий аймаг дахь хэлтэс нь 1 арга хэмжээ төлөвлөх шаардлагатай ч төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлээгүй бол газар нэгжүүдийн хамтарсан 3 арга хэмжээ байгаагаас Захиргаа, удирдлагын газар, Гадаад харилцаа, судалгаа хамтын ажиллагааны хэлтэс 1 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлжээ.

“Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ” буюу төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд

байгууллагын төлөвлөгөөнд 5 арга хэмжээг тусгаснаас Мэдээллийн технологийн хэлтэс 1 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн.

Хүснэгт 1.

Д/д	Нэгжийн нэр	Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний тоо	Тухайн сард тусгагдсан арга хэмжээний тоо	Дараа сард тусгах шаардлагатай арга хэмжээний тоо
1	2	3	4	5
1	Захиргаа, удирдлагын газар	13	6	12
2	Виз, зөвшөөрлийн газар	2	2	2
3	Иргэний харьяаллын газар	5	1	5
4	Зөрчил шалган шийдвэрлэх газар	3	2	3
5	Санхүү, хангалт, үйлчилгээний газар	4	1	4
6	Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс	3	-	3
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс	6	2	5
8	Мэдээллийн технологийн хэлтэс	5	1	5
9	Зөвлөгөө, мэдээллийн хэлтэс	1	1	1
10	Баян-Өлгий аймаг дахь хэлтэс	1	-	1
11	Захиргаа, удирдлагын газар, Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс хамтарсан	1	1	1
12	Виз, зөвшөөрлийн газар, Иргэний харьяаллын газар, Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс хамтарсан	1	-	1
13	Зөрчил шалган шийдвэрлэх газар, Мэдээллийн технологийн хэлтэс хамтарсан	1	-	1
14	Мэдээллийн технологийн хэлтэс, Зөвлөгөө, мэдээллийн хэлтэс хамтарсан	1	-	1
15	Захиргаа, удирдлагын газар, Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо хамтарсан	2	-	2
Нийт		49	17	47

Мөн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй ч зарим арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор газар нэгжүүд үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн 21 арга хэмжээ байна. Үүнд:

Хүснэгт 2.

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Зорилт	Хариуцах газар нэгж
1.	2.	3.	4.	5.

1	Дээд шатны байгууллагыг гадаадын иргэний зөрчлийн мэдээллээр хангах	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 73 дугаар зарлигаар баталсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэн болон хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэлийн талаарх сар тутмын мэдээллийг 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01/47 дугаар албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд хүргүүлсэн.	Зорилт 1. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт “Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна.”	Зөрчил шалган шийдвэрлэх газар
2	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулах гэрээний эрх зүйн үндэслэлийг хянаж, холбогдох журмын төсөлд санал өгөх	Төв байрны урсгал засварын гэрээ, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн (спорт заал ашиглах) гэрээний төслийг тус тус хянаж, санал тусган дугаар олгосон.	Зорилт 2. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ.	Захиргаа, удирдлагын газар
3	Байгууллагын үйл ажиллагааны сарын төлөвлөгөө батлуулах	Байгууллагын үйл ажиллагааны 02 дугаар сарын төлөвлөгөөнд тусгах саналыг зохион байгуулалтын нэгжүүдээс ирүүлснийг нэгтгэн боловсруулж, байгууллагын даргаар 01 дүгээр сарын 30-ны өдөр батлуулан Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (ERP)-ээр албан хаагчдад танилцуулсан.		
4	Байгууллагын үндсэн үйл ажиллагааны 7 хоног тутмын тойм мэдээг Хууль зүй, дотоод хэргийн сайдад танилцуулах	Байгууллагын үндсэн үйл ажиллагааны 4 удаагийн 7 хоног тутмын тоон мэдээ болон онцлох мэдээг ВЗГ, ИХГ, ЗШШГ-аас авч нэгтгэн боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдад цахимаар танилцуулав.		
5	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	Хууль зүй, дотоод хэргийн сайдын аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нартай зохион байгуулах уулзалтад холбогдох мэдээллийг 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01/09 дүгээр, Төрийн үйлчилгээний чанар,		

		хүртээмжийг нэмэгдүүлэх, засаглал, хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр 2016-2025 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний танилцуулга, мэдээллийг 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01/202 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.		
6	Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2025 оны нэгдсэн тайланг хүргүүлэх	Төрийн албаны зөвлөлийн 01 дүгээр сарын 08-ны өдрийн 04/36 албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан, “Төрийн байгууллагын 2025 оны чадахуйн зарчмын хэрэгжилт үнэлэх шалгуур”-ын биелэлтийг нэгтгэн байгууллагын даргын 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01/136 албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газарт хүргүүлсэн. Мөн үйл ажиллагааны тайлангийн хавсралт нотлох баримтыг хариуцсан албан хаагчийн цахим хаягаар хүргүүлсэн.	Зорилт 2. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ.	Захиргаа, удирдлагын газар
7	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг khutulbur.iaac.mn цахим сүлжээнд тайлагнах	Авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийг хэрэгжүүлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг “Авлигын эсрэг үндэсний сүлжээ” цахим системд нотлох баримтын хамт 01 дүгээр сарын 27-ны өдөрт багтаан тайлагнаж, баталгаажуулсан бөгөөд Захиргаа, удирдлагын газрын даргын 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02/194 албан бичгээр Авлигатай тэмцэх газрын Авлигатай		

		тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтэст мэдэгдсэн. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт байгууллагын даргын 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01/210 албан бичгээр үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлсэн.		
8	Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны 2025 оны тайланг хүргүүлэх	Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны тайланг нэгтгэн боловсруулж, байгууллагын даргын 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01/10 дугаар албан бичгээр Монгол Улсын Ёс зүйн хороонд хүргүүлсэн.	Зорилт 2. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ.	Захиргаа, удирдлагын газар
9	Албан хаагчдын 2026 оны ээлжийн амралтын хуваарийг батлуулах	Албан хаагчдын 2026 оны ээлжийн амралтын хуваарийг байгууллагын даргын 01 дүгээр сарын 14-ний өдрийн Б/10 дугаар тушаалаар баталж, холбогдох нэгжүүдэд хүргүүлсэн.		
10	Удирдах албан тушаалтны цугларалт зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах	Байгууллагын даргын 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/16 “Удирдах албан тушаалтны цугларалт зохион байгуулах тухай” тушаалаар баталсан удирдамжийн дагуу цугларалтыг 01 дүгээр сарын 13, 14-ний өдрүүдэд зохион байгууллаа. Цугларалтад төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн 40 албан хаагч хамрагдсан ба үр дүнг 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01-02/05 дугаар илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан.		
11	Байгууллагын үйл ажиллагаа, эрхлэх чиг үүрэгтэй холбоотой мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудас, цахим сүлжээ, хэвлэл мэдээллийн	Байгууллагын цахим хуудсанд үйл ажиллагаатай холбоотой 9 мэдээ, цахим сүлжээнд 19 мэдээлэл байршуулж, давхардсан тоогоор 53 хэвлэл, мэдээллийн хэрэгсэл (48		

	хэрэгслээр олон нийтэд мэдээлэх	сайт, 3 сонин, 2 телевиз)-ээр сурталчиллаа.		
12	Байгууллагын даргын дэргэдэх зөвлөлийн хурал болон мэргэжлийн зөвлөлийн хурлын товыг гаргаж, зохион байгуулах	Байгууллагын даргын дэргэдэх зөвлөлийн 2 удаагийн хурлыг 01 дүгээр сарын 05-ны өдөр, Мэргэжлийн зөвлөлийн 2 удаагийн хурлыг 01 дүгээр сарын 05, 23-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж, хурлын тэмдэглэл хөтлөн баталгаажуулсан.	Зорилт 2. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт	Захиргаа, удирдлагын газар
13	Албан хаагчдын албан хэрэгцээнд архивын баримтыг ашиглалтад олгох	Архивд хадгалагдаж буй хадгаламжийн нэгжээс 6 албан хаагчид 42 хадгаламжийн нэгж түр олгож, хууль хяналтын байгууллага, иргэнээс ирүүлсэн 51 хүсэлтэд 826 хуудас архивын баримтыг “хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулан олгож, бүртгэл үйлдэн ажиллалаа.		
14	Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт хамрагдаж, нэгдсэн дүнг танилцуулах	Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт 01 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд хамрагдсан. Үзлэгийн дүгнэлт одоогоор албажиж ирээгүй байна.		
15	Гадаадын иргэний бүртгэл, хяналтын 12 дугаар сарын мэдээ, 2025 оны харьцуулсан танилцуулга мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх	Гадаадын иргэний бүртгэл, хяналтын хяналтын 12 дугаар сарын болон 2025 оны жилийн эцсийн өмнөх онтой харьцуулсан танилцуулга мэдээг 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01/18 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлж, танилцуулгыг төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем (ер)-д 01 дүгээр сарын 07-ны өдөр нийтэлсэн.	Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ.	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс
16	Төсвийн шууд захирагчийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргаж, хилийн боомт,	Төсвийн шууд захирагчийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын	Зорилт 2. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг	Санхүү, хангалт, үйлчилгээний газар

	орон нутаг дахь нэгжтэй тооцоо нийлэн тодруулга тайлбар гаргах	стандартад нийцүүлэн гаргаж, 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/176 дугаар албан бичгээр харьяа аудитын байгууллагад хүргүүлсэн. Төсвийн шууд захирагчдын хоорондын тооцоог 30 удаагийн актаар баталгаажуулж, бараа материал, үндсэн хөрөнгийн хоорондын тооцоог цахим болон цаасан хэлбэрээр тулган баталгаажуулсан болно.	хэрэгжүүлэх зорилт Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ.	
17	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвтэй холбоотой мэдээ, тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх	Төсвийн шууд захирагч болон төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн 12 дугаар сарын мэдээг нэгтгэн 01 дүгээр сарын 05-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж баталгаажуулсан.		
18	Зөвлөгөө, мэдээллийн чиглэлээр цахим сургалт зохион байгуулах	Хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, шинэ мэдээ, мэдээллээр хангах зорилгоор цахим сургалтыг 01 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулж, 48 албан хаагч хамрагдсан. Сургалтын талаар мөн өдрийн 10/01 дүгээр илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан.		Зөвлөгөө, мэдээллийн хэлтэс
19	Байгууллагын үйл ажиллагааны сарын тайлан нэгтгэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Байгууллагын үйл ажиллагааны 12 дугаар сарын төлөвлөгөөнд тусгагдсан 2 зорилтын 31 арга хэмжээний биелэлтийг нэгтгэн боловсруулж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн тайланг 01 дүгээр сарын 07-ны өдөр удирдлагад танилцуулж, Захиргаа, удирдлагын газарт зөвлөмжийг хүргүүлсэн. Хэрэгжилт 87.6 хувьтай үнэлэгдсэн.		Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс
20	Нэгжүүдийн 2026 оны гүйцэтгэлийн	Байгууллагын төв болон хилийн боомт, орон нутаг		

	төлөвлөгөө батлуулах ажлыг зохион байгуулах	дахь 17 нэгжийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ хийн холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тусгуулж, байгууллагын даргаар 01 дүгээр сарын 07-ны өдөр батлуулсан.		
21	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд цахим хуудаст байршуулсан 2025 оны дөрөвдүгээр улирлын тоон мэдээлэлд хяналт шалгалт хийх	Төв байгууллагаас 01 дүгээр сард цахим хуудсанд тухай бүр тайлагнах 10, сар бүр тайлагнах 4, жил бүр тайлагнах 3, нийт 17 мэдээг хуулийн хугацаанд байршуулсан. Байгууллагын даргын 2026 оны 01-08/01 дугаар удирдамжийн дагуу төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдийн Шилэн дансны тухай хуулийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд дотоод аудит хийн үр дүнг 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01-08/03 дугаар илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан. Шилэн дансны тухай хуулийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01/68 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шалгалт, дотоод аудитын газарт хүргүүлээ.	Зорилт 2. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ.	Санхүү, хангалт, үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс

Дүгнэлт, зөвлөмж

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-аар урт хугацааны бодлогын баримт бичиг, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт түүний суурь түвшин болон зорилтот түвшинтэй харьцуулан үнэлгээ өгдөг тул цаашид энэхүү журмаар байгууллагын үйл ажиллагаанд сар бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжгүй болж байгаа юм.